



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын “Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээр”, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны “Шимтгэлийн доод хэмжээг батлах тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Бүгд Найрамдах Солонгос Улсад ажиллаж, амьдарч буй иргэдийг нийгмийн даатгалд хамруулах, шимтгэлийг санд төвлөрүүлэх, тайлан мэдээ гаргах журам”-ыг нэгдүгээр, “Бүгд Найрамдах Солонгос Улсад гэрээгээр ажилласан Монгол улсын иргэдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг Санхүү бүртгэлийн газар /Б.Даваахүү/, БНСУ дахь Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын үйлчилгээний төв /Д.Баярмандах/-д нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд дарга /Г.Саран/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Журам шинэчлэн батлах тухай” 2010 оны 08, 2014 оны 110 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.ЗОРИГТ

015110111



НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСАД
АЖИЛЛАЖ, АМЬДАРЧ БУЙ ИРГЭДИЙГ
НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРУУЛАХ,
ШИМТГЭЛИЙГ САНД ТӨВЛӨРҮҮЛЭХ, ТАЙЛАН
МЭДЭЭ ГАРГАХ ЖУРАМ

Баримт бичгийн дугаар: СҮАЖ-СБГ-...-2021

Баталсан: НДЕГ-ын дарга

Д.ЗОРИГТ

Хянасан: СГБ-ын дарга

Б.ДАВААХҮҮ

Боловсруулсан: СБГ-ын мэргэжилтэн

Л.БОЛОРМАА

Эх хувь	
Хяналттай хувь	
Хуулбар хувь	
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	

Баримт бичгийн үзүүлэлт

Журмын хариуцагч	Баримт бичгийн дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
НДЕГ-ын ТГ				

Өөрчлөлтийн тухай тэмдэглэл

Хувилбар	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1	2014.08.10 №110	Журам шинэчлэн батлах тухай	НДБХГ-ын ахлах мэргэжилтэн Б.Батжаргал
Хувилбар 2	2021.03. №	Журам шинэчлэн батлах тухай	СБГын мэргэжилтэн Л.Болормаа
Хувилбар 3			



Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2021 оны 03 дугаар сарын
04 өдрийн /15 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

**БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСАД АЖИЛЛАЖ, АМЬДАРЧ БУЙ ИРГЭДИЙГ
НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРУУЛАХ, ШИМТГЭЛИЙГ САНД ТӨВЛӨРҮҮЛЭХ,
ТАЙЛАН МЭДЭЭ ГАРГАХ ЖУРАМ**

НЭГ. Зорилго

Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын “Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах” хэлэлцээр, Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны “Шимтгэлийн доод хэмжээг батлах тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн БНСУ-д ажиллаж, амьдарч буй Монгол улсын иргэдийг нийгмийн даатгалд даатгуулах, тэтгэвэр, тэтгэмж олгох харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

ХОЁР. Хамрах хүрээ

БНСУ-д гэрээгээр ажиллаж буй Монгол улсын иргэдийг тэтгэврийн даатгалд /цаашид албан журмын даатгуулагч гэх/, гэрээнээс бусад ангиллаар тус улсад оршин сууж, ажил хөдөлмөр эрхэлж буй иргэдийг сайн дурын нийгмийн даатгалд /цаашид сайн дурын даатгуулагч гэх/ тус тус хамруулах, нийгмийн даатгалд даатгуулсан тухай гэрээ байгуулах, гэрчилгээ олгох, нийгмийн даатгалын шимтгэл төлөх, төвлөрүүлэх, бүртгэх, мэдээ тайлан гаргах, мэдээллийн санд бүртгэх, тэтгэмж олгох, сурталчилгаа хийх, хяналт тавих, хариуцлага тооцох үйл ажиллагаа хамаарна.

ГУРАВ. Хамаарах талууд

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл хариуцсан нэгж, БНСУ дахь Нийгмийн Хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасаг /цаашид тасаг гэх/.

ДӨРӨВ. Баримт бичгийг хариуцагч

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл хариуцсан нэгж

ТАВ. Нийгмийн даатгалд хамруулах

5.1. Албан журмын даатгалд хамруулах

5.1.1. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар зөвшөөрөгдөж урилга нь ирсэн Монгол улсын иргэдэд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж болон тэтгэврийн даатгалд даатгуулах тухай сургалтыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн “Ажиллах хүч гадаадад гаргах” эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулна.

5.1.2. Санхүү бүртгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн болон тасгийн мэргэжилтэн нь даатгуулагч иргэнтэй “Тэтгэврийн даатгалд даатгуулсан тухай” гэрээ байгуулж, гэрчилгээ олгоно. Гэрчилгээ нь Монгол хэл, Солонгос хэл дээр байна. Гэрчилгээг гурван хувь үйлдэж, эх хувийг Санхүү бүртгэл хариуцсан нэгж/тасаг/-д, хоёр дахь хувийг албан журмын даатгуулагчид, гурав дахь хувийг ажил олгогчид тус тус өгнө.

5.1.3. “Тэтгэврийн даатгалд даатгуулсан тухай” гэрчилгээ нь албан журмын даатгуулагчийн регистрийн дугаар болон гадаад паспортын дугаартай байх бөгөөд Нийгмийн даатгалын байгууллагын тамга, эрх бүхий албан тушаалтны гарын үсгээр баталгаажсан байна.

5.1.4. “Тэтгэврийн даатгалд даатгуулсан тухай” гэрчилгээ нь албан журмын даатгуулагчийг БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөх эрх зүйн баримт болно.

5.1.5. Тасаг нь БНСУ дахь ажил олгогч болон даатгуулагчтай гурвалсан гэрээ байгуулж болох бөгөөд гэрээний хувийг тасаг, ажил олгогч, албан журмын даатгуулагчид тус тус өгч, гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Энэ гэрээ болон гэрчилгээнд зөвхөн тэтгэврийн даатгалд даатгуулсан тухай дурдана.

5.2. Сайн дурын даатгалд хамруулах

5.2.1. Тасаг нь БНСУ-д хуанлийн 90 хоногоос дээш хугацаагаар оршин сууж буй хөдөлмөрийн насанд хүрсэн дараах иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулна. Үүнд:

- а) Суралцагсад;
- б) 90 хоногоос дээш хугацаагаар зорчин очигсад;
- в) БНСУ-ын аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсад;
- г) Бусад.

5.2.2 Тасаг нь гадаад паспорт, БНСУ-д оршин суух түр үнэмлэхийн аль нэг (эсвэл хуулбар)-ийг үндэслэн иргэнтэй нийгмийн даатгалын сайн дурын даатгалд даатгуулсан тухай гэрээ /цаашид гэрээ гэх/ байгуулна.

5.2.3. БНСУ-д оршин суух түр үнэмлэхээр гэрээ байгуулсан тохиолдолд сайн дурын даатгуулагчийн регистрийн дугаарыг гэрээнд заавал бичсэн байна.

5.2.4. Сайн дурын даатгуулагч гэрээг тасагтай байгуулснаар нийгмийн даатгалын дараах төрөлд хамрагдана. Үүнд:

5.2.4.1. Тэтгэврийн даатгал;

5.2.4.2. Тэтгэмжийн даатгал;


5.2.4.3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал;

5.2.5. Сайн дурын даатгуулагч гэрээ байгуулсан нь БНСУ-ын тэтгэврийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

ЗУРГАА. Нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ, шимтгэл төлөх

6.1. Албан журмын даатгалд хамрагдсан даатгуулагчид нийгмийн даатгалын шимтгэл төлөх БНСУ-ын “Хана”, “Шинхан”, “Үри”, “Күкмин” банкны воны харилцах дансны дугаарыг давхардуулахгүйгээр олгох ба эрх зүйн актаар тогтоосон 40000 /дөчин мянга/ воноос багагүй шимтгэлийг сар бүр төлүүлнэ.

6.2. Сайн дурын даатгалд хамрагдсан даатгуулагчид нийгмийн даатгалын шимтгэл төлөх БНСУ-ын холбогдох банкны воны харилцах дансны дугаарыг мөн давхардуулахгүйгээр олгох ба сайн дурын даатгуулагч гэрээгээр тохирсон мөнгөн дүнгээс сайн дурын даатгалын шимтгэлийн хувь, хэмжээгээр сарын 40 000 /дөчин мянга/ воноос багагүй шимтгэлийг гэрээнд заасан хугацаанд олгосон дансанд төлнө.



6.3. Нийгмийн даатгалын шимтгэлийг зөвхөн тухайн даатгуулагчид олгосон харилцах дансанд төлүүлэх ба бусад даатгуулагчийн нэр, дансыг сольж шилжүүлэхийг хориглоно. Хэрэв нийгмийн даатгалын шимтгэл төлөхдөө харилцах данс, даатгуулагчийн нэрийг андуурч буруу шилжүүлсэн бол тасаг нь анхан шатны баримтыг үндэслэн залруулга хийх ба холбогдох програмд залруулга хийсэн тухай мэдээлэл хадгалагдана.

6.4. Тасаг нь энэ журмын 5.2-т заасны дагуу гэрээ байгуулсан сайн дурын даатгуулагч гэрээгээр тохирсон хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлээ төлөөгүй бол Нийгмийн даатгалын тухай хуульд заасны дагуу хугацаандаа төлөөгүй шимтгэлийг алдангийн хамт нөхөн төлүүлнэ.

6.5. Даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны “Шимтгэлийн доод хэмжээг тогтоох тухай” 05 дугаар тогтоол, дээд хэмжээг Засгийн газрын 2017 оны “Нийгмийн даатгалын шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээг тогтоох тухай” 251 дүгээр тогтоолыг тус тус мөрдөнө.

ДОЛОО. Нийгмийн даатгалын шимтгэлийг төвлөрүүлэх, бүртгэх, мэдээ тайлан гаргах

7.1. Тасаг нь гэрээ байгуулсан даатгуулагчдаар нийгмийн даатгалын шимтгэлийг гэрээнд заасан хугацаанд БНСУ-ын холбогдох банк дахь шимтгэл төлөх харилцах дансанд төлүүлж, даатгуулагч тус бүрээр “Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тооцооны хуудас”-ыг дараах маягтын дагуу хөтөлнө. Үүнд:

№	Овог, нэр	Иргэний үнэмлэхийн регистрийн дугаар (эсвэл БНСУ-д оршин суух эрхийн үнэмлэхийн дугаар)	Банкны нэр	Дансны дугаар	Санд төлсөн шимтгэл		
					Огноо	Аль сарын	Нийт дүн

7.2. Тасаг нь нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын мэдээллийг БНСУ-ын харилцагч банкнаас даатгуулагч тус бүрээр дараа сарын 01-ний өдрийн дотор гаргуулан авч тулган шалган нэгтгэж, архивын нэгж болгон хадгална.


7.3. Тасаг нь албан журмын даатгуулагчийн харилцах дансанд воноор төлөгдсөн нийгмийн даатгалын шимтгэлийг тэтгэврийн даатгалын сангийн харилцах дансанд 100.0 хувь шилжүүлнэ.

7.4. Сайн дурын даатгуулагчийн харилцах дансанд воноор төлөгдсөн нийгмийн даатгалын шимтгэлийг тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн харилцах дансанд ногдуулалтын хувиар тус тус тооцон сар бүр бүрэн хуваарилж, шилжүүлнэ.

7.5. Тасаг нь даатгуулагчийн харилцах дансанд воноор төлөгдсөн нийгмийн даатгалын шимтгэлийг Монгол Улсын Төрийн банк дахь дансанд тухайн өдрийн ханшаар тооцож, америк доллараар дараах байдлаар сар бүр шилжүүлнэ. Үүнд:

а) Албан журмын даатгалд даатгуулсан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын тэтгэврийн даатгалын сангийн харилцах дансанд;

б) Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд даатгуулсан даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын тэтгэврийн даатгалын сан, тэтгэмжийн даатгалын сан, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн харилцах дансанд тус тус төвлөрүүлнэ.



7.6. Энэ журмын 7.5-д дурдсан дансанд америк доллараар шилжиж орсон даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг хүлээн авсан өдрийн "Төрийн" банкны бэлэн бусаар худалдаж авах ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэнэ.

7.7. Тасаг нь тухайн сарын ханшийн бүртгэлийн жагсаалт хөтөлж, архивийн нэгж болгон хадгална.

7.8. Тасаг нь холбогдох журам, зааврын дагуу нийгмийн даатгалын сангийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөх ба харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулж, сар бүрийн мэдээг дараа сарын 01-ний дотор, улирлын тайланг дараа сарын 10-ны дотор тус тус Санхүү бүртгэл хариуцсан нэгжид ирүүлнэ.

7.9. Тасаг нь нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт төлөлтийн тооцоог гэрчилгээ авсан даатгуулагч тус бүрээр 1-12 сараар гарган хянан баталгаажуулж, архивын нэгж болгон хадгална.

НАЙМ. Мэдээллийн санд оруулах

8.1. Тасаг нь энэхүү журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой програм хангамж ашиглана.

8.2. Тасаг нь даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалт, төлөлтийн тооцоог тухайн даатгуулагчийн гэрээ, даатгуулагчид олгосон харилцах дансанд төлөгдсөн шимтгэлийн дүн, харилцагч банкнаас авсан дансны мэдээлэл, "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тооцооны хуудас"-ыг тус тус мэдээллийн санд үнэн зөв оруулна.

8.3. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн гүйлгээнд залруулга гарсан тохиолдолд энэхүү журмын 8.1-д заасан програм хангамжид холбогдох мэдээллийн өөрчлөлт, залруулгыг оруулна.

ЕС. Нийгмийн даатгалын дэвтэр

9.1. Даатгуулагч нь цахим нийгмийн даатгалын дэвтэртэй байна.

9.2. Даатгуулагчид зориулсан вэб програм, "Нийгмийн даатгал" аппликейшнээр нийгмийн даатгалын цахим дэвтэр харах, хэвлэн авах боломж бүрдсэн байна.

9.3. Санхүү бүртгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн нь нутаг буцаж ирсэн иргэдийн /тус газарт хадгалагдаж байгаа/ нийгмийн даатгалын дэвтрийг хүлээлгэн өгч гарын үсэг зуруулна.

АРАВ. Тэтгэмж олгох

10.1. Энэ журмын 5.2-д заасны дагуу гэрээ байгуулсан сайн дурын даатгуулагч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасан болзол, нөхцөлийг хангасан бол тэтгэвэр, тэтгэмж авах эрхтэй.

10.2. Сайн дурын даатгуулагчид тэтгэмж олгох үйлчилгээг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар томилсон нийгмийн даатгалын хэлтэс хариуцна.

10.3. Энэ журмын 10.1-д заасан болзол, нөхцөлийг хангасан сайн дурын даатгуулагч нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль тогтоомжид заасан баримт бичгийг бүрдүүлсэн байна.



10.4. Сайн дурын даатгуулагч энэ журмын 10.3-т зааснаас гадна БНСУ-ын талын эрх бүхий байгууллагаас олгосон дараах баримт бичгийг бүрдүүлж тасагт өгнө. Үүнд:

а) Жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах тухай хувийн хүсэлт

б) Эмнэлгийн байгууллагаас олгосон тодорхойлолт /жирэмсний болон амаржсаны, эмчлүүлсэн тухай/;

в) Эрх бүхий байгууллагаас олгосон үйлдвэрлэлийн ослын акт;

г) Энэ журмын 1, 2 дугаар хавсралтаар батлагдсан Нийгмийн даатгалын тасгийн болон ажил олгогчийн тодорхойлолт;

д) Тэтгэмж хүлээн авах Монгол дахь банкны нэр, дансны дугаар;

10.5. Тасаг нь энэ журмын 10.4-т дурдсан баримт бичгийн үнэн зөв үндэслэлийг тухай бүр БНСУ-ын холбогдох байгууллагаас шалган уг бичиг дээр шалгасан тухай тэмдэглэл хийж, бүртгэл хөтөлнө.

10.6. Сайн дурын даатгуулагч тэтгэмжийг Монгол Улсад өөрөө ирж авах бол холбогдох Нийгмийн даатгалын хэлтэст хандана. Харин БНСУ-д амьдарч байхдаа тэтгэмж авах бол тасагт хандан өргөдөл, баримт бичгээ бүрдүүлж өгөх ба тасаг баримт бичгийг хянаж, энэхүү журмын 10.2-т заасан Нийгмийн даатгалын хэлтэст эхний ээлжинд цахим хэлбэрээр болон эх хувийг 14 хоногийн дотор хүргүүлнэ. Энэ тохиолдолд сайн дурын даатгуулагч Монгол дахь тэтгэмж хүлээн авах банкны нэр, дансны дугаарыг журмын 10.4.а-д заасан хүсэлтэд тодорхой бичсэн байна.

АРВАН НЭГ. Сурталчилгаа хийх

11.1. БНСУ-д амьдарч буй иргэдэд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, ач холбогдлыг сурталчлах, тэдгээрийг нийгмийн даатгалд хамруулах ажлыг Тасаг хариуцан гүйцэтгэх ба журмын 5.1, 5.2-т дурдсан даатгуулагчдад чиглэсэн сурталчилгааны арга хэрэгслийг сонгон хэрэгжүүлнэ.

11.2. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь БНСУ-д ажиллах Монгол Улсын иргэдэд Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн талаар сургалт, сурталчилгааг Хөдөлмөр, Халамжийн Үйлчилгээний Ерөнхий газартай хамтран зохион байгуулна.


11.3. Нийгмийн даатгалын ерөнхий газар нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр хүчин төгөлдөр болж мөрдөгдсөнөөс хойшхи хугацаа (2007 оны 03 дугаар сарын 01-ээс хойш)-нд БНСУ-д гэрээ болон үйлдвэрлэлийн дадлагажигчаар ажиллаж буй Монгол улсын иргэдийг тэтгэврийн даатгалд хамруулж, гэрчилгээ олгосон болон холбогдох мэдээллийг БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба болон тасагт хүргүүлнэ.

АРВАН ХОЁР. Хориглох зүйлс

12.1. Санхүү бүртгэл хариуцсан нэгж болон тасаг, холбогдох мэргэжилтнүүдэд дараах үйлдлийг хориглоно.

12.1.1. Энэ журмын 5.1, 5.2-т тус тус заасны дагуу гэрчилгээ олгогдоогүй, гэрээ байгуулаагүй, гэрээ байгуулсан боловч нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй иргэдийг шимтгэл төлснөөр нөхөн, мэдээллийн санд бүртгэх;

12.1.2. Сайн дурын даатгуулагч гэрээнд заасан хугацаанд төлөөгүй нийгмийн даатгалын шимтгэлийг албан журмын даатгал төлсөн мэтээр мэдээллийн санд бүртгэх.



АРВАН ГУРАВ. Хяналт тавих


13.1. Тасаг нь албан журмын болон сайн дурын даатгуулагчийн шимтгэл гэрээнд заасан хугацаанд төлөгдөж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах бөгөөд шаардлагатай бол Нийгмийн даатгалын ерөнхий газарт мэдэгдэн хамтарч ажиллана.

13.2. Тасгийн үйл ажиллагаа, гэрээ хэлэлцээрийн хэрэгжилт, нийгмийн даатгалын хамралт, шимтгэлийн орлого төвлөрүүлэлт, үйл ажиллагааны зардлын зарцуулалт, мэдээллийн сангийн бүрдүүлэлт, анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн үндэслэлд тавих хяналтыг хууль тогтоомжоор эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан өөрийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлнэ.

АРВАН ДӨРӨВ. Хариуцлага

14.1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, энэхүү журамд заасан үүргийг хэрэгжүүлээгүй зөрчил гаргасан гэм буруутай ажилтанд холбогдох хууль, тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

14.2. Хуурамч баримт бичиг бүрдүүлж үндэслэлгүй тэтгэмж авсан болох нь хяналт шалгалтаар нотлогдсон даатгуулагчаар гаргасан зөрчлийг бүрэн барагдуулж, холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.



САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧИЙН ЭМЧЛҮҮЛСЭН ТУХАЙ ТОДОРХОЙЛОЛТ

20 ... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Дугаар ...

Даатгуулагчовогтой(регистрийн дугаар БНСУ-д оршин суух түр үнэмлэхний дугаар) нь эмнэлэгт ердийн өвчин, ахуйн осол, үйлдвэрлэлийн осолын /зур/ улмаас 20 . . . оны . . . дугаар сарын . . . -ны өдрөөс 20 . . . оны . . . дугаар сарын . . . -ны өдөр хүртэл . . . хоногийн хугацаанд оношоор эмчлүүлснийг нотолсон БНСУ-ын эрх бүхий байгууллагын тодорхойлолт нь үнэн зөв болохыг тодорхойлов. Тодорхойлолтын орчуулгыг хавсаргав.

Тодорхойлолт гаргасан:

Нийгмийн даатгалын тасгийн дарга / /
тэмдэг /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

Нийгмийн даатгалын

байцаагч (ажилтан) / /
/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал

АЖИЛ ОЛГОГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ

20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

Дугаар ...

Монгол Улсын иргэн овогтой (регистрийн дугаар , БНСУ-д оршин суух түр үнэмлэхний дугаар) нь ердийн өвчин, ахуйн осол, үйлдвэрлэлийн осолд орсон /зур/ улмаас өвчний учир 20 . . . оны . . . дугаар сарын . . . -ны өдрөөс 20 . . . оны . . . дугаар сарын . . . -ны өдөр хүртэл хоногийн хугацаанд ажил (хичээл)-аас /зур/ чөлөөлөгдсөн нь үнэн болохыг тодорхойлов.

Тодорхойлолт гаргасан:

тэмдэг

Байгууллага (сургууль)-ийн дарга (захирал)

/гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/



САЙН ДУРЫН ДААТГУУЛАГЧИЙН ЖИРЭМСНИЙ БОЛОН АМАРЖСАНЫ
ТОДОРХОЙЛОЛТ

..... эмнэлэгт жирэмсний хяналтад байсан, амаржсан /зур/ даатгуулагч
..... овогтой (регистрийн
дугаар БНСУ-д оршин суух түр үнэмлэхний дугаар)
нь оны дугаар сарын -ний өдрөөс жирэмсний амралт эхэлсэн,
амаржсан /зур/ болохыг нотолсон БНСУ-ын эрх бүхий байгууллагын тодорхойлолт
нь үнэн зөв болохыг тодорхойлов. Тодорхойлолтын орчуулгыг хавсаргав.

Тодорхойлолт гаргасан:

Нийгмийн даатгалын

тасгийн дарга /

/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал/

тэмдэг

Нийгмийн даатгалын

байцаагч (ажилтан) /

/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал

АЖИЛ ОЛГОГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ

20... оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар ...

..... эмнэлэгт жирэмсний хяналтад байсан, амаржсан /зур/
Монгол Улсын иргэн овогтой
(регистрийн дугаар, БНСУ-д оршин суух түр үнэмлэхний дугаар
.....) нь тул ажил (хичээл)-аас /зур/ чөлөөлөгдсөн нь үнэн болохыг
тодорхойлов.

Тодорхойлолт гаргасан:

тэмдэг

Байгууллага (сургууль)-ийн
дарга (захирал)

/гарын үсэг/

/гарын үсгийн тайлал/





НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСАД ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАСАН МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ БУЦААН ОЛГОХ ЖУРАМ

Баримт бичгийн дугаар: СУАЖ-СБГ-...-2021

Баталсан: НДЕГ-ын дарга  Д.ЗОРИГТ
Хянасан: СГБ-ын дарга  Б.ДАВААХҮҮ
Боловсруулсан: СБГ-ын мэргэжилтэн  Л.БОЛОРМАА

Эх хувь	
Хяналттай хувь	
Хуулбар хувь	
Хүчингүй хувь	
Хяналтгүй хувь	

Баримт бичгийн үзүүлэлт

Журмын хариуцагч	Баримт бичгийн дугаар	Баталсан огноо	Мөрдөж эхлэх огноо	Хуудасны тоо
НДЕГ-ын ТГ				

Өөрчлөлтийн тухай тэмдэглэл

Хувилбар	Өөрчлөлт оруулсан огноо	Өөрчлөлтийн утга	Өөрчлөлт оруулсан ажилтан
Хувилбар 1	2010.01.08 №05	Журам шинэчлэн батлах тухай	Ё.Пүрэвцэрэн
Хувилбар 2	2021.03. №	Журам шинэчлэн батлах тухай	СБГ-ын мэргэжилтэн Л.Болормаа
Хувилбар 3			



Нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2021 оны 09 дугаар сарын
09 өдрийн АБС дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСАД ГЭРЭЭГЭЭР АЖИЛЛАСАН МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ БУЦААН ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. Зорилго

Нийгмийн даатгалын тухай хууль, Монгол Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар болон Бүгд Найрамдах Солонгос Улс/цаашид БНСУ гэх/-ын Үндэсний тэтгэврийн алба хоорондын харилцан ойлгоцлын санамж бичиг, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн тухай хуулийн 77 дугаар зүйл (буцаан олгох шимтгэл), 127 дугаар зүйл (Гадаад улс оронтой байгуулсан нийгмийн хамгааллын хэлэлцээр), “Гадаадын иргэнд олгох шимтгэлийн талаарх мэдээлэл” (2006.1.26)-ийг үндэслэн БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажилласан Монгол улсын иргэдийн БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, тэдний тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаагаар нь Монгол Улсын тэтгэврийн даатгалд даатгуулж, уг санд нэг удаа шимтгэл төлүүлэх харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

ХОЁР. Хамрах хүрээ

БНСУ-ын Үндэсний тэтгэврийн алба /цаашид УТА гэх/-нд шимтгэл төлсөн иргэдийн шимтгэлийг нэхэмжилж, иргэнд буцаан олгох, тус улсад тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн хугацаагаар Монгол Улсын тэтгэврийн даатгалын санд шилжүүлэн даатгал хийлгэх үйл ажиллагаа хамаарна.

ГУРАВ. Хамаарах талууд

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн, БНСУ дахь Нийгмийн Хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасаг /цаашид тасаг гэх/, Төв орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсийн тэтгэврийн даатгалын шимтгэл буцаан олголт хариуцсан байцаагч нар, УТА-аас шимтгэл буцаан авах иргэд.

ДӨРӨВ. Баримт бичгийг хариуцагч

Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл хариуцсан нэгж

ТАВ. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг буцаан олгоход тавигдах шаардлага

5.1. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байх хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулж, шимтгэл төлсөн Монгол улсын иргэд эх орондоо буцаж ирсэнээс хойш 5 жилийн дотор төлсөн шимтгэлийг түүнд тооцсон хүүгийн хамт БНСУ-ын УТА-аас нэг удаа буцаан авна.

5.1.1. Энэхүү журмын 5.1-д заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд тэтгэврийн насанд хүрээд нэхэмжлэх эрхтэй

5.2. Тэтгэврийн даатгалын шимтгэл буцаан авах иргэд БНСУ-ын “Цагаачлалын хуулийн тусгай зүйлийн 1-д зааснаар Е-8 (дадлагажигч), Е-9 (мэргэжлийн бус гэрээт ажилтан), Н-2 (зочин мэргэжилтэн) гэсэн оршин суух визний ангиллаар хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулан шимтгэл төлсөн, гэрээний хугацаа дуусч эх орондоо буцсан Монгол улсын иргэд байна.

5.3. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байх хугацаандаа ҮТА-д тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн мэдээллийг тус улсаас ирүүлсэн мэдээлэлтэй тулган шалгана.

5.4. Энэхүү журмын 5.3-д заасан мэдээлэл нь байхгүй иргэн өөрийн биеэр "Хувийн мэдээллийн лавлагаа /даатгалд хамрагдаж эхэлсэн, дууссан хугацаа, шимтгэл төлсөн нийт сарын тоо, төлсөн шимтгэлийн дүн болон буцаан олголт авах тухай/"-г ҮТА-аас авна.

ЗУРГАА. Тэтгэврийн даатгалын шимтгэл буцаан авах иргэдийн бүрдүүлэх баримт бичиг

6.1. Нэхэмжлэгч иргэн нь зөвхөн өөрийн биеэр тэтгэврийн даатгалын шимтгэл буцаан авах тухай хүсэлт гаргах ба доор дурдсан баримт бичгийг бүрдүүлнэ.

6.1.1. Гадаад паспортын хуулбар /зурагтай, Е-8, Е-9, Н-2 ангилал бүхий виз, сунгалтын хугацаа, хоёр улсын хилээр орсон, гарсан тэмдэглэгээ бүхий хуудсуудын хуулбар/, (гадаад паспорт үрэгдүүлсэн бол гадаад паспорт авч байсан тухай болон хилээр орж ирсэн тухай лавлагаа, орчуулгын хамт);

6.1.2. Нэхэмжлэх анкет (англи хэл дээр);

6.1.3. Гадаад мөнгөн шилжүүлгийн маягт (англи хэл дээр)

6.1.4. Нэхэмжлэгчийг тухайн банкинд ам.долларын данс эзэмшигч гэдгийг баталсан банкны албан бичиг (англи хэл дээр)

6.1.5 Монгол Улсын Иргэний үнэмлэхийн хуулбар;

6.1.6 Бүртгэлийн хураамжийг банкин дахь дансанд төлсөн орлогын баримт;

6.2. Тэтгэврийн даатгалын шимтгэл буцаан авах иргэн нас барсан бол:

6.2.1. Нас барсан иргэний шимтгэлийг нэхэмжилж авах эрх бүхий иргэний биеийн байцаалт /эхнэр нөхөр, төрсөн хүүхэд, төрсөн эцэг, эх/ (орчуулгын хамт);

6.2.2. Нас барсан хүний иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, нас барсны гэрчилгээ (орчуулгын хамт);

6.2.3. Гэрлэлтийн баталгаа /гэр бүлгүй тохиолдолд гэрлээгүй гэсэн албан ёсны тодорхойлолт/ (орчуулгын хамт);

6.2.4 Эцэг, эх нь нэхэмжлэх тохиолдолд аль нэгнийх нь гараар бичсэн хүсэлт бичиг, тэдгээрийн аль нэг нь нас барсан бол нас барсны гэрчилгээ (орчуулгын хамт);


6.2.5 Эх нь нэхэмжлэл гаргасан тохиолдолд төрсний гэрчилгээний хуулбар эсхүл иргэний бүртгэлийн лавлагаа (орчуулгын хамт);

6.3. Энэ зүйлийн 6.2-т заасан баримт бичгийг нэхэмжлэх эрх бүхий этгээд нь англи эсвэл солонгос хэл дээр хууль ёсны баталгаат орчуулга хийлгэсэн байна.

ДОЛОО. Тэтгэврийн даатгалын шимтгэл буцаан авах иргэдийн бүртгэл, мэдээлэл

7.1. Санхүү бүртгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн нь нэхэмжлэгч иргэний баримт бичгийг үндэслэн ҮТА-аас батлагдсан нэхэмжлэх анкет, гадаад мөнгөн шилжүүлгийн маягтыг програм хангамж ашиглан англи хэл дээр бөглөж, бүртгэнэ.

7.2. Санхүү бүртгэл хариуцсан нэгжийн мэргэжилтэн нь тэтгэврийн даатгалын шимтгэл буцаан авах иргэдийн нэхэмжлэх анкет, гадаад мөнгөн шилжүүлгийн маягт, бүрдүүлсэн баримт бичгийг эх хувьтай нь тулган шалгаж хүлээн авч, бүртгэл хөтөлнө.



7.3. ҮТА-аас тэтгэврийн даатгалын шимтгэл буцаан авах хүсэлт иргэдийн нэхэмжлэх анкет, баримт, материалыг шалгаж баталгаажуулан тасгаар дамжуулан ҮТА-д хүргүүлнэ.

7.4. Нийгмийн даатгалын ерөнхий газраас хүргүүлсэн Монгол улсын иргэдийн баримт бичгийг ҮТА хүлээн авч, хянан шалгаж, зохих тэтгэврийн даатгалын шимтгэлийг буцаан олгохоор зөвшөөрөн, тухайн иргэний нэр дээрх банкин дахь валют /ам.доллар/-ын дансанд шилжүүлсэн тухай эсвэл шимтгэл буцаан олгох боломжгүй хариу ирүүлсэн тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага нь тухайн иргэнд мэдээлэл өгнө.

НАЙМ. Монгол Улсын тэтгэврийн даатгалд шилжүүлэн даатгах, шимтгэл төлөх орлого, шимтгэлийн хувь хэмжээ, хугацаа

8.1. ҮТА-аас тэтгэврийн даатгалын шимтгэл буцаан авах эрх үүссэн иргэд БНСУ-ын шимтгэл төлсөн хугацаагаар Монгол Улсын тэтгэврийн даатгалд сайн дураар хамрагдаж болно.

8.2. Энэ журмын 8.1-д БНСУ-д оршин суух E8, E9 статустай, хөдөлмөрийн гэрээгээр 2002 оны 04 дүгээр сараас хойш ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн Монгол Улсын иргэд нэг удаа хамрагдана.

8.3. БНСУ-ын ҮТА-ын тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн хугацаанд шилжүүлэн тооцох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээг тухайн үед мөрдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байх бөгөөд дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнээс хэтрэхгүй байна.

8.4. Төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллага нь тухайн даатгуулагчтай “Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулсан тухай гэрээ”-г байгуулах замаар сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг хэмжээг харилцан тохиролцох бөгөөд шимтгэл ногдуулах хувь, хэмжээг тухайн үеийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь, хэмжээгээр тооцож, тухайн хугацааны шимтгэлийг тэтгэврийн даатгалын санд нэг удаа бүрэн төлүүлнэ.

8.5. Буцаан олгох шимтгэлийг БНСУ-д нэхэмжлэн авсан иргэд Монгол Улсад орж ирсэн өдрөөс хойш 3 сарын дотор харьяа нийгмийн даатгалын байгууллагад хандан Монгол Улсын тэтгэврийн даатгалд шилжүүлэн даатгуулж, Монгол Улсын тэтгэврийн даатгалын санд зохих шимтгэлийг төлж болно.

ЕС.Хориглох зүйлс

9.1. Төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллага нь ҮТА-д тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн тухай мэдээлэл ирээгүй иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн хугацаанд шилжүүлэн тооцож, мэдээллийн баазад бүртгэхийг хориглоно;


АРАВ. Хяналт шалгалт

10.1 Энэхүү журмын хэрэгжилтэд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Санхүү бүртгэл хариуцсан нэгж, Хяналт, шалгалт хариуцсан нэгж болон хууль, тогтоомжоор эрх олгогдсон байгууллага, албан тушаалтан тус тусын эрх үүргийн хүрээнд хэрэгжүүлнэ.

АРВАН НЭГ. Оролцогч талуудын үүрэг

11.1. Нийгмийн даатгалын төв байгууллага дараах үүрэгтэй.

11.1.1. Нийгмийн даатгалын тухай хууль болон энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавих, дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргах,



11.1.2. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын байцаагч нарт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх,

11.2. Тасаг дараах үүрэгтэй.

11.2.1. Буцаан олголтын нэхэмжлэх, анкетыг ҮТА-д шуурхай хүргүүлэх, хариуг авч Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх, холбогдох мэдээ, мэдээллээр хангах;

11.3. Төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллага дараах үүрэгтэй.

11.3.1. Нийгмийн даатгалын тухай хууль болон энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллах,

11.3.2. ҮТА-аас тэтгэврийн даатгалын шимтгэл буцаан авсан иргэдээс шилжүүлэн даатгал хийлгэхийг хүссэн иргэдийн даатгалыг тооцож, санд төвлөрүүлэх;

АРВАН ХОЁР. Хариуцлага

12.1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, энэхүү журамд заасан үүргийг хэрэгжүүлээгүй зөрчил гаргасан гэм буруутай ажилтанд холбогдох хууль, тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

